



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/6/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас:7058-4203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас:7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас:7058-4207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	7
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	8
2.8.3 Авлага.....	8
2.8.4 Урьдчилгаа.....	8
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	8
2.8.6 Бараа материал	9
2.8.7 Үндсэн хөрөнгө	9
2.8.8 Өр төлбөр.....	9
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо	10
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.11. Шилэн дансны мэдээлэл	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ДОА	Дорнод аймаг



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Аудитын гэрчилгээ

 ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203		ЧОЙБАЛСАН СУМЫН ЗАСАГ ДАРГА Ц.АРИУНБОЛД ТАНАА	
2020.03.25 № 320			
танай	-ны №	-т	
Аудитын гэрчилгээ			
Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чойбалсан сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.			
Зөрчилгүй санал дүгнэлт			
Чойбалсан сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.			
Санал дүгнэлтийн үндэслэл			
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.			
Аудитаар Чойбалсан сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.			
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.			
110520264			



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ц.Ариунболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Чойбалсан сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-наас 2020 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах гүйцэтгэв.

Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/74 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Чойбалсан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Чойбалсан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, аудитын алба нь 2019 онд Чойбалсан сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр зөвлөмж өгөөгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Чойбалсан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 16 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг зардлын 1 хувь буюу 31.6 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 төрийн /орон нутгийн/ өмчит аж ахуйн нэгж, 2 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 5 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, сумын ЗДТГ-т “Хязгаарлалттай” дүгнэлт өгч, 3 байгууллагын тайланг түүвэрт хамруулан шалгаж, илэрсэн асуудлыг нэгтгэсэн тайланд тусгалаа.



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 83.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү, алдангийн орлогын 8.8 сая төгрөгийн тусгаагүй 1 алдааг аудитын явцад залруулж, 74.7 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн үзүүлэлт байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

1. Орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт тусгагдан батлагдсан 72,000.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээг тайлант онд хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7 дэх хэсэгт "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.
2. ИТХ нь худалдан авалтын 2,723.8 мянган төгрөгийн анхан шатны Е баримтыг хавсаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад "анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5 дахь хэсэгт "... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 "татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах". гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 5,520.0 мянган төгрөгийн залруулга хийлээ. Үүнд:

- Чойбалсан сумын ЗДТГ: ОНХС-гаас нийлүүлсэн 3,100.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоомыг орлогод аваагүй, нэмэлт санхүүжилтийн данснаас багаж тоног төхөөрөмж худалдан авахаар 2,420.0 мянган төгрөгийг шилжүүлж, хөрөнгийг хүлээн аваагүй байхад орлогоор бүртгэсэн байсныг тус тус санхүүгийн тайланд залруулсан.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, өцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 141.6 сая, өцсийн үлдэгдэл 192.1 сая төгрөг болж, 50.5 сая төгрөгөөр өссөн байна.~~



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт №1. <u>Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл</u> /сая төгрөг/				
<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	141.6	192.1	+50.5	
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	
Дүн	141.6	192.1	+50,5	

Formatted Table

Formatted Table

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 192.1 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд оны бичилт хийгдээгүй байна.

2.8.3 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 169.7 сая, эцсийн үлдэгдэл 197.8 сая төгрөг болж, 28.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын <u>үлдэгдэл</u> /сая төгрөг/				
<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-	-	
Төлбөртэй үйлчилгээний авлага	165.7	194.2	+28.5	
Бусад авлага	4.0	3.6	-0.4	
Зээлийн авлага	-	-	-	
Дүн	169.7	197.8	28.1	

Авлагын үлдэгдэлд СХС-гийн зээл, зээлийн хүүтэй холбоотой үүссэн 3-4 жилийн насжилтай 98.2 сая төгрөгийн авлага, 1 жилийн насжилтай 96.0 сая төгрөгийн авлага байна. Энэ нь сангаас аж ахуй нэгж, иргэнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд үзүүлэх зээл олголтод сөрөг үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү, алдангийн орлогын 8.8 сая төгрөгийг тайланд тусгаагүй байсныг аудитын явцад залруулсан.

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансанд бичилт хийгдээгүй байна.

2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

ДОА-2020/6/СТА-ТТЗ



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 420.3 сая, эцсийн үлдэгдэл 439.0 сая төгрөг болж, 18.7 сая төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	13.9	13.8	-0.1
Эм боох материал	2.1	6.3	+4.2
Бичиг хэрэг	5.3	5.1	-0.2
Аж ахуйн материал	167.6	185.9	+18.3
Сэлбэг хэрэгсэл	0.6	0.6	-
Хүнсний материал	0.4	0.4	--
Бусад хангамжийн материал	61.6	58.1	-3.5
Мал амьтад	168.7	168.7	-
Дүн	420.3	439.1	+18.7

Бараа материалын үлдэгдэл өссөн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай аж ахуйн материалыг худалдан авсантай холбоотой байна.

Мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал байхгүй байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 5,751.3 сая, эцсийн үлдэгдэл 6,587.2 сая төгрөг болж, 835.9 сая төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	3,534.4	4,252.1	717.7
Тээврийн хэрэгсэл	151.1	151.1	-
Машин тоног төхөөрөмж	243.0	283.2	40.2
Тавилга эд хогшил	161.5	170.9	9.4
Түүх соёлыг дурсгалт зүйлс	12.5	12.5	-
Номын фонд	11.8	18.2	6.4
Бусад үндсэн хөрөнгө	1482.9	1,544.2	61.3
Программ хангамж	4.5	5.5	1.0
Биет бус хөрөнгө	149.4	149.4	-
Дүн	5,751.3	6,587.2	835.9

Үндсэн хөрөнгө нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 716.1 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 94.6 сая, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 25.2 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөр ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. 6.2 сая төгрөгөөр буюу 100 хувь буурсан байна~~

ДОА-2020/6/СТА-ТТЗ



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	6.2	0,0	-6.2	100
Нийт дүн	6.2	0.0	-6.2	

Богино хугацаат өр төлбөр буурсан нь өмнөх оны ажиллагсадтай холбоотой нийгмийн даатгалын шийтгэлийг барагдуулсантай холбоотой байна.

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,285.7 сая, эцсийн үлдэгдэл 5,950.9 сая төгрөг болж, 665.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/- бууралт	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,876.9	1,815.9	-61.0	
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	61.0	+61.0	
Хуримтлагдсан үр дүн	1,786.2	2,451.4	665.2	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,622.4	1,622.4	0	
Дүн	5,285.7	5,950.9	665.2	100.0

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto

Formatted Table

Formatted: Font: (Default) Arial, 10 pt, Bold, Mongolian (Cyrillic)

Засгийн газрын оруулсан капитал данс 61.0 сая төгрөгөөр буурсан нь өмчит үйлдвэрийн газар, төсвийн байгууллагын мөнгөн дүнг салган харуулснаас шалтгаалсан байна.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Чойбалсан сумын ИТХ-ын 2019 оны орон нутгийн төсөв батлах тухай 03 дугаар тогтоолд сумын төсвийн орлогын төлөвлөгөө 35.0 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 45.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 129.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хувь хүний орлогын албан татвар	16.0	12.2	4.3	74.1
Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний татвар	2.0	14.3	12.2	713.6
Хадгаламжийн хүүгийн татвар	8.5	9.0	0.5	106.0
Өмчийн татвар буу	2.5	1.8	0.7	72.3
Улсын тэмдэгтийн хураамж	2.5	1.1	1.4	43.0



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүү торгуулийн орлого	1.5	2.0	0.5	132.9
Бусад	1.5	5.0	3.5	332.4
Нийт дүн	35.0	45.4	10.4	129.7

Төсвийн орлого 10,4 сая төгрөгөөр давсан нь Хавирга-Архашаат хилийн боомт дээр орон тооны бус байцаагчийг томилон, улс хооронд зорчигч тээврийн хэрэгслийн татвар хураалтыг тогтмолжуулж, хадгаламжийн хүүгийн орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,073.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,834.9 сая төгрөгийг урсгал зардалд, 238.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,108.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 917.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 27.5 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 18.3 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас, 1.0 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,108.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 917.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, нийгмийн даатгалын сангаас 6.2 сая төгрөгийн санхүүжилтийг авсан нь гүйцэтгэлээр олгогдсонтой холбоотой байна. Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 18.3 сая төгрөгийг санхүүжилтийг олгоогүй байна. Туслах үйл ажиллагааны орлогын 1.0 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,889.7 мянган төгрөг буюу 91,1 хувьтай байгаа нь Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх төсөл хөтөлбөр арга хэмжээ бүрэн хийгдээгүй, орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 16 төсөл, арга хэмжээнд 194,448.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 178,103.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 395,188.5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,005.4 мянга, нийт 405,396.7 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс: Хангамж, бараа материалын зардалд 745.3 мянган төгрөг, норматив зардалд 1,300.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 29,499.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 513.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 91,543.5 мянган төгрөг, нийт 405,396.7 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. Сумдын засаг дарга нар нь Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-д хамаарахгүй, урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулахаар захирамж гаргаж байгааг анхаарах шаардлагатай байна.

2. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 18.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Чойбалсан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 136 мэдээллийг хугацаанд нь, 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 82,109.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Чойбалсан сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	731 565 427,40	828 950 287,24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	141 561 198,66	192 109 730,79
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	141 561 198,66	192 109 730,79
3121	Төгрөг	141 561 198,66	192 109 730,79
31211	Төрийн сангийн харицах	141 561 198,66	192 109 730,79
33	АВЛАГА	169 691 067,13	197 786 175,04
335	Бусад авлага	169 691 067,13	197 786 175,04
3351	Байгууллагаас авах авлага	4 037 469,68	3 586 097,59
3352	Хувь хүмүүсээс авах авлага	165 653 597,45	194 200 077,45
35	БАРАА МАТЕРИАЛ	420 313 161,61	439 054 381,41
351	Түүхий эд материал	16 046 450,91	20 133 759,35
35110	Тусгай зориулалттай материал	13 868 870,07	13 824 670,07
35130	Эм боох материал	2 177 580,84	6 309 089,28
354	Хангамжийн материал	235 532 760,70	250 186 672,06
35410	Бичиг хэргийн материал	5 277 625,05	5 131 700,05
35420	Аж ахуйн материал	167 612 638,07	185 932 819,07
35430	Сэлбэг хэрэгсэл	638 182,00	638 182,00
35460	Хүнсний материал	418 029,20	421 595,00
35470	Бусад хангамжийн материал	61 586 286,38	58 062 375,94
35600	Мал амьтад	168 733 950,00	168 733 950,00
2	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	4 560 276 590,29	5 126 868 727,02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4 560 276 590,29	5 126 868 727,02
392	Биет хөрөнгө	4 409 526 965,46	4 975 879 677,25
39201	Барилга, байгууламж, орон сууц	3 534 384 755,77	4 252 127 415,77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(42 514 239,37)	(173 049 259,86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	151 143 028,80	151 143 028,80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(112 638 737,12)	(127 179 914,77)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	243 017 375,30	283 228 755,30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(165 762 411,68)	(194 881 670,12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	161 511 151,49	170 868 351,49
39208	Хуримтлагдсан элэгдэл	(93 240 425,32)	(106 366 275,90)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	12 500 000,00	12 500 000,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1 482 899 582,20	1 544 240 582,20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(773 619 304,61)	(854 949 505,66)
39217	Ном	11 846 190,00	18 198 170,00
393	Биет бус хөрөнгө	150 749 624,83	150 989 049,77
39301	Програм хангамж	4 532 540,00	5 464 740,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3 236 915,17)	(3 929 690,23)
39303	Бусад биет бус хөрөнгө	149 454 000,00	149 454 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	5 291 842 017,69	5 955 819 014,26



Чойбалсан сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6 160 059,21	39 584,70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6 160 059,21	39 584,70
413	Өглөг	6 160 059,21	39 584,70
4136	Бусад өглөг	390 243,30	39 584,70
